1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.10.02 № 1/1535

танай ____________ -ны № ____________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Тодруулга өгөх тухай

Тус эмнэлгээс зарласан ЭМЯ/20240102047 дугаар бүхий тендерт оролцогч компани тодруулга авах хүсэлтээ ирүүлсэн. Үүнд:

1. Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн "9. Coil (Стандарт): - Foot/Ankle 18 ch-аас багагүй" гэж шаардсан байгаа.

Асуулт: Энэ тендерт байгаа бусад койлны үзүүлэлтүүд 16 ch (сувгаас) хэтрэхгүй байгаа болович зөвхөн шагайн койлны үзүүлэлтийг өндөр сувгийн тоотой (18 ch) шаардаж байгаа нь Siemens компанийн MRI аппарат санал болгох компанид л давуу байдал олгож байгаа, гэтэл тус аппаратны техник шаардлага 3. RF technology хэсэгт "Number of independent receiver channels that can be used simultaneously in one single scanand in one single FoV, each genetating an independent partial image -8,16" гэж бичсэн байгаа хэсэгтэй зөрчилдөж байна, учир нэг шинжилгээнд нэгэн зэрэг ашиглаж болох сувгийн тоо нь дөнгөж 8 ба 16 гэж шаардсан болович шагайн койлыг 18 сувагтай байх гэж шаардаж байгаа нь хоорондоо авцалдахгүй, тухайн тендерийн шаардлагаар эрхтний койлны суваг хэд ч байсан 16 сувгаас илүүг ашиглах боломжгүй байна. Үүнээс энэ "foot/Ankle 18 ch-аас багагүй" нэг бол андуурч бичигдсэн, эсвэл зөвхөн өрсөлдөөн хязгаарлах л үүрэгтэй л гэж харагдаж байна.

Иймээс "9. Coil (Стандарт): -Food/Ankle 16 ch-аас багагүй" гэж өөрчилсөн тохиолдолд тус шаардлага нь бусад тендерийн техникийн шаардлагатай зөрчилдөхгүй, бүх компаниудад ижил тэгш өрсөлдөх боломжоор хангах боломжтой байна.

Дээрх тодруулгад доорх хариуг өгч байна.

Тус эмнэлгийн тендерийн баримт бичгийн "Соронзон резонанст томографийн аппаратын техникийн тодорхойлолт"- ын 9. Coil (Стандарт): -д Foot/Ankle 16 ch - аас багагүй гэсэн шаардлага тавигдсан. Knee 18 ch –аас багагүй байх гэж шаардсан шаардлагыг "Knee 16 ch –аас багагүй байж болно" давуу тал болохгүй гэсэн тайлбарыг өгч байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.БЯМБАСҮРЭН

АТА9995 90771
9023050128

002699